



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/009/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: О.Анхбаяр
Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө	11
3.4.2 Авлага	12
3.4.3 Бараа материал	12
3.4.4 Үндсэн хөрөнгө	12
3.4.5 Өр төлбөр	13
3.4.5 Засгийн газрын хувь оролцоо	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар	20
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	21
5.1 Албан шаардлага	22
5.2 Зөвлөмж	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

САЙХАН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.МӨНХТӨР ТАНАА

2025.03.25 № СА-2025/009/НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар болон санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын хүрээнд илэрсэн дараах зөрчлүүд нь ХХОАТ-ын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 22 дугаар зүйлийн 22.1.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4.5, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.3, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 2, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний

ангилал” дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Сумын ИТХ, ЗДТГ, Номгон тосгоны Захирагчийн алба нь орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас нийт **4,456.2** мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй,
- Сумын ИТХ, ЗДТГ нь батлагдсан төсвийг зориулалт бусаар, хөтөлбөр, зориулалт, зардлын бүлэг хооронд **11,853.5** мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй,
- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс Хот тохижилтын газар нь **6,487.4** мянган төгрөгийн НДШ-ийн өр төлбөр үүсгэсэн,
- ЗДТГ нь өмнөх оны аудитаар өгсөн нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээр худалдан авсан бараа материалыг бүртгэл тайланд тусгах зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд **20,000.0** мянган төгрөгийн нөөцийн өвс, тэжээлийг бараа материалын дансанд орлого авалгүйгээр шууд зардлаар тайлагнасан,
- ЗДНС, мөрийн хөтөлбөрийн зардал болон Номгон тосгоны Захирагчийн албаны төсвөөс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтыг зөрчиж **31,911.6** мянган төгрөгийн ажил, гүйлгээ хийсэн,
- Нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулахаас зайлсхийж, харьцуулалтын аргын босго үнэд багтаах зорилгоор ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжихээр төлөвлөсөн **185,000.0** мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээг 2 төсөл, арга хэмжээ болгон төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд 3-р цэцэрлэг, 1-р сургууль зэрэг төсөвт байгууллагуудын 2023 онд халаалтын тарифын зөрүүнээс болж үүссэн 73,970.4 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөгийг шинээр бүртгэснээс шалтгаалан өр төлбөр дансны үлдэгдэл 76,248.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Аудитын гол асуудал

Тус сумын Хот тохижилтын газар нь төсвийн эх үүсвэрээр бүрэн санхүүжиж байгаа боловч Төрийн сангийн нэгдсэн дансны системд **дансгүй** бөгөөд ЗДТГ-ын төрийн сан дахь 100130955001 дугаар данснаас байгууллагын ХААН банкин дахь 5048334545 тоот дансаар дамжуулан 515,943.9 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банканд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд **төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ**” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Сайхан сумын Засаг дарга нь тайлант онд мөрийн хөтөлбөрийн биелэлтээ тайлагнаагүй учир сумын ИТХ-аар хэлэлцэж дүгнээгүй байна

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,073,719.7	1,790,050.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,582,601.9	1,408,142.9
33	АВЛАГА	403,082.2	279,611.4
35	БАРАА МАТЕРИАЛ	88,035.5	102,296.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,380,787.1	8,486,881.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,380,787.1	8,486,881.3
39200	Биет хөрөнгө	4,830,014.4	7,935,708.5
39300	Биет бус хөрөнгө	550,772.7	551,172.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,454,506.8	10,276,931.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,031.1	91,280.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,031.1	91,280.0
41300	Өглөг	15,031.1	91,280.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,439,475.7	10,185,651.6
51	Засгийн газрын хувь оролцоо	7,439,475.7	10,185,651.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	792,655.1	793,055.1
51200	Хуримтлагдсан үр дүн	5,763,648.9	8,509,424.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	883,171.7	883,171.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,454,506.8	10,276,931.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,271,632.0	9,953,950.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,715,659.4	5,206,778.2
110	Орлогын албан татвар	2,766,978.8	4,121,744.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	2,980,609.1	4,466,409.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-213,630.3	-344,665.6
113	Хөрөнгийн албан татвар	589,238.7	801,369.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	359,441.8	283,664.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,640,318.4	3,930,171.2
120	Нийтлэг татварын бус орлого	1,640,318.4	3,930,171.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	915,654.2	817,000.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,507,275.9	5,819,212.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,443,938.6	5,819,212.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,441,308.6	5,592,726.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	822,621.3	1,585,677.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,194.0	201,763.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,998.1	2,657,233.0
2104	Хангамж, бараа материалын зардал	78,029.5	139,319.7
2105	Нормативт зардал	523.0	6,729.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,399.2	204,381.5
2107	Томилолт, зочны зардал	8,313.5	11,911.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,241,942.0	80,810.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,068,288.1	704,901.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,630.0	226,486.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	63,337.2	0.0

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,764,356.1	4,134,737.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,062,408.8	1,380,803.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	701,947.3	2,753,933.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,663,068.7	6,663,068.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,663,068.7	6,663,068.7
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	74,459.6	74,459.6
9	Тайлант үеийн үр дүн	701,947.3	701,947.3
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,439,475.7	7,439,475.7
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,439,475.7	7,439,475.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-8,157.8	-8,157.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,431,317.9	7,431,317.9
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	400.0	400.0
19	Тайлант үеийн үр дүн	2,753,933.8	2,753,933.8
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,185,651.6	10,185,651.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,062,342.6	6,540,559.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,715,659.4	5,206,778.2
110	Орлогын албан татвар	2,766,978.8	4,121,744.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	2,980,609.1	4,466,409.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-213,630.3	-344,665.6
113	Хөрөнгийн албан татвар	589,238.7	801,369.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	359,441.8	283,664.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	98,109.8	176,464.2
1181	Газрын төлбөр	257,924.5	102,059.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,407.5	5,141.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	431,029.0	495,125.5
120	Нийтлэг татварын бус орлого	431,029.0	495,125.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	915,654.2	838,655.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,929,405.9	5,197,110.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,929,405.9	5,197,110.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,926,775.9	4,970,624.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	822,893.7	1,587,837.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,194.0	201,763.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,998.1	2,583,262.6
2104	Хангамж, бараа материалын зардал	64,833.6	127,456.5
2105	Нормативт зардал	360.0	9,843.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,467.0	200,566.5
2107	Томилолт, зочны зардал	8,313.5	11,911.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,242,350.1	79,380.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	570,365.9	168,603.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,630.0	226,486.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,132,936.6	1,343,448.4

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,180,363.0	1,509,749.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,180,363.0	1,509,749.6
2200	Дотоод эх үүсвэрээр	1,180,363.0	1,509,749.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,180,363.0	-1,509,749.6
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-248,400.0	-8,157.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	248,400.0	8,157.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-295,826.3	-174,459.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,878,428.2	1,582,601.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,582,601.9	1,408,142.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт /хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,852,282.30	6,558,201.01	-1,294,081.29	83.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,344,534.70	5,074,797.69	-269,737.01	95.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,237,105.20	4,970,615.03	-266,490.17	94.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,729,588.60	1,587,837.80	-141,750.80	91.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	226,784.20	201,763.07	-25,021.13	89.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,637,565.60	2,583,262.58	-54,303.02	97.9
2104	Хангамж, бараа материалын зардал	130,263.30	124,047.08	-6,216.22	95.2
2105	Нормативт зардал	11,501.20	9,843.24	-1,657.96	85.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	226,172.90	225,070.60	-1,102.30	99.5
2107	Томилолт, зочны зардал	13,096.80	11,911.00	-1,185.80	90.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	79,173.00	58,276.24	-20,896.76	73.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	182,959.60	168,603.42	-14,356.18	92.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	107,429.50	104,182.66	-3,246.84	97.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	107,429.50	104,182.66	-3,246.84	97.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,210,943.80	1,475,245.52	-735,698.28	66.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	296,803.80	8,157.80	-288,646.00	2.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,852,282.30	6,658,909.77	-1,193,372.53	84.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	0.00	
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,283,785.00	6,533,278.16	-750,506.84	89.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	568,497.30	125,631.61	-442,865.69	22.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	389,009.75	389,009.75	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	489,718.49	489,718.49	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	96	96	0	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	47	47	0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	47	47	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,875.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,875.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,875.15
2104	Хангамж, бараа материалын зардал	3,409.38
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,465.77
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34,875.15
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,875.15

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сайхан сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Монгол улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024, аймгийн болон сумын Засаг даргын 2022-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2022-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлэх,
- Гадаад дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлж, шинэ техник технологийг нутагшуулах,
- Үйлдвэр, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дугаар сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлт тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

2024 онд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Сайхан сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2022-2023 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт, шалгалт хийж 8,157.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, төлбөрийн акт тогтоосон байна. Мөн аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сайхан сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан “Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,822,424.8 мянган төгрөгөөр буюу 37.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,582,601.90	1,408,142.90	-174,459.00
Авлага	403,082.20	279,611.40	-123,470.80
Бараа материал	88,035.50	102,296.10	14,260.60
Үндсэн хөрөнгө	5,380,787.20	8,486,881.20	3,106,094.00
Нийт хөрөнгө	7,454,506.80	10,276,931.60	2,822,424.80
Өр төлбөр	15,031.10	91,280.00	76,248.90
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,439,475.70	10,185,651.60	2,746,175.90
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,454,506.80	10,276,931.60	2,822,424.80

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсныг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,408,142.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 174,459.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	1,582,601.90	1,408,142.90	-174,459.00
Төгрөг	1,582,601.90	1,408,142.90	-174,459.00
Төрийн сангийн харилцах	1,582,601.90	1,408,142.90	-174,459.00
Дүн	1,582,601.90	1,408,142.90	-174,459.00

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 915,861.9 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 278,042.5 мянган төгрөг, барьцаа дансны үлдэгдэл 2,562.5 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн үлдэгдэл 211,676.0 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 279,611.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 123,470.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	30,807.90	14,189.10	-16,618.80
Байгууллагаас авах авлага	0.00	2,160.80	2,160.80
Хувь хүмүүсээс авах авлага	6,066.70	6,066.70	0.00
Хувь хүмүүст олгосон зээл	366,207.60	257,194.80	-109,012.80
Дүн	403,082.20	279,611.40	-123,470.80

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны нийт авлагын үлдэгдлийн 97.0 хувь буюу 271,384.0 мянган төгрөгийг Хоршоог хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлагын үлдэгдэл эзэлж байна. Үүнээс 44,181.4 мянган төгрөг буюу 16.2 хувь нь 2011-2017 оны хооронд олгосон хугацаа хэтэрсэн зээлийн авлага байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 102,296.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 14,260.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	59,500.00	66,428.80	6,928.80
Тусгай зориулалттай материал	59,500.00	66,428.80	6,928.80
Эм боох материал	0.00	0.00	0.00
Хангамжийн материал	28,535.50	35,867.30	7,331.80
Бичиг хэргийн материал	1,256.30	3,789.30	2,533.00
Аж ахуйн материал	26,162.50	22,049.50	-4,113.00
Сэлбэг хэрэгсэл	730.00	2,160.00	1,430.00
Түлш, шатах тослох материал	70.00	210.10	140.10
Барилгын засварын материал	0.00	6,158.40	6,158.40
Бусад хангамжийн материал	316.70	1,500.00	1,183.30
Дүн	88,035.50	102,296.10	14,260.60

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 14,260.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 204,230.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 189,969.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, сумын хөрөнгө оруулалтаар 454,730.6 мянган төгрөгийн, ОНХС-ийн эх үүсвэрээр 926,072.8 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэж, бусад хангамжийн материалын дансаар дамжуулан хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлснээс тус тус шалтгаалсан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 8,486,881.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,106,094.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,830,014.50	7,935,708.50	3,105,694.00
Барилга, байгууламж, орон сууц	1,065,958.40	3,572,413.70	2,506,455.30
Авто-тээврийн хэрэгсэл	103,670.80	327,560.50	223,889.70
Машин тоног төхөөрөмж(компьютер)	101,477.90	233,944.80	132,466.90
Тавилга, аж ахуйн эд хогшил	23,691.90	38,026.00	14,334.10
Зам, гүүрний байгууламж	426,832.00	385,139.80	-41,692.20
Бусад үндсэн хөрөнгө	3,108,383.50	3,378,623.70	270,240.20
Биет бус хөрөнгө	550,772.70	551,172.70	400.00
Программ хангамж	0.00	0.00	0.00
Бусад биет бус хөрөнгө	550,772.70	551,172.70	400.00
Дүн	5,380,787.20	8,486,881.20	3,106,094.00

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 3,106,094.0 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил, гүйлгээнээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2,527,267.8 мянган төгрөгийн залуучууд хөгжлийн ордныг шилжүүлэн авсан,
- Улсын онцгой комиссоос 187,000.0 мянган төгрөгийн автомашин шилжүүлэн авсан,
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 180,181.0 мянган төгрөгийн гэрэлтүүлэг бүртгэж авсан зэргээс голлон шалтгаалсан байна.

3.4.5 Өр төлбөр

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 91,280.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 76,248.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	6,487.40	6,487.40
Байгууллагад төлөх өглөг	10,822.20	84,792.60	73,970.40
Хувь хүмүүст төлөх өглөг	4,208.90	0.00	-4,208.90
Дүн	15,031.10	91,280.00	76,248.90

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны нийт өр төлбөрийн үлдэгдэл 91,280.0 мянган төгрөг болж 76,248.9 мянган төгрөгөөр өссөн нь төсөвт байгууллагуудын 2023 онд үүссэн тогтмол зардлын 73,970.4 мянган төгрөгийг өр төлбөрийг нөхөж бүртгэснээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- 3-р цэцэрлэг 8,154.7 мянган төгрөг,
- 1-р сургууль 65,815.7 мянган төгрөг,

3.4.5 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 10,185,651.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,746,175.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	792,655.10	793,055.10	400.00
Хуримтлагдсан үр дүн	5,763,648.90	8,509,424.80	2,745,775.90
Өмнөх үеийн үр дүн	5,061,701.60	5,755,491.00	693,789.40
Тайлант үеийн үр дүн	701,947.30	2,753,933.80	2,051,986.50
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	883,171.70	883,171.70	0.00
Дүн	7,439,475.70	10,185,651.60	2,746,175.90

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл урьд оноос 2,746,175.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Сайхан сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн “2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 19 дүгээр тогтоолоор 4,896,126.4 мянган төгрөгийн татварын орлого, 336,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого нийт **5,232,126.4** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **5,576,272.2** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг **6.6** хувиар давж биелүүлсэн байна.

Хүснэгт 9. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	4,896,126.40	5,206,778.25	310,651.85	106.3
Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	3,599,376.60	3,692,446.45	93,069.85	102.6
Үйл ажиллагааны орлого	307,172.00	430,995.52	123,823.52	140.3
Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	0.00	0.00	0.00	
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	600,000.00	691,332.98	91,332.98	115.2
Иргэний ҮХХБор албан татвар	134,105.00	143,296.04	9,191.04	106.9
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-344,665.60	-344,665.60	0.00	100.0
Галт зэвсгийн албан татвар	1,500.00	880.72	-619.28	58.7
Улсын тэмдэгтийн хураамж	42,212.60	54,001.29	11,788.69	127.9
Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр	0.00	0.00	0.00	
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	15,000.00	16,969.29	1,969.29	113.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	190.00	70.20	-119.80	36.9
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.00	0.00	0.00	
Байгалийн ургамал ашигласны төлбөр	10,000.00	5,070.83	-4,929.17	50.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	90,000.00	105,493.62	15,493.62	117.2

Газрын төлбөр	50,000.00	51,489.14	1,489.14	103.0
Дуудлага худалдаа	50,000.00	50,570.04	570.04	101.1
Хадгаламжийн хүүгийн орлого	191,235.80	199,671.84	8,436.04	104.4
Малын тоо толгойн албан татвар	150,000.00	109,155.88	-40,844.12	72.8
Татварын бус орлого	336,000.00	369,493.92	33,493.92	110.0
Хүү торгуулийн орлого	300,000.00	352,920.21	52,920.21	117.6
Хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлого	36,000.00	16,573.71	-19,426.29	46.0
Нийт дүн	5,232,126.40	5,576,272.17	344,145.77	106.6

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 93,069.9 мянган төгрөгөөр давж биелсэн нь 2024 оны 4 дүгээр сараас төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэн,
- Үйл ажиллагааны орлого нь 123,823.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь 12 дугаар сард олгогдсон хувьцааны ногдол ашгаас татвар суутгасан,
- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 91,333.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь татварын ногдох хөрөнгийн үнэлгээнд өөрчлөлт орсноор татварын хэмжээ нэмэгдсэн,
- Хүү торгуулийн орлого 52,920.2 мянган төгрөгөөр давж биелсэн нь баруун таван сумын хүү торгуулийн орлого төвлөрсөн зэргээс голлон шалтгаалсан байна.

Тасарсан орлогууд:

- Малд ногдох албан татвар 40,844.1 мянган төгрөгөөр тасарсан нь Номгон тосгонд татварын байцаагчгүй учир малчдад хүрч ажиллаж чадаагүй,
- Бусад орлого 19,426.3 мянган төгрөгөөр тасарсан нь тайлант онд бусад төрлийн зөвшөөрөл, эрх олгогдоогүй зэргээс голлон шалтгаалсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 63,933,6 мянган төгрөгөөр, татварын болон татварын бус орлогоос 3,554,500.0 мянган төгрөгөөр, урд оны үлдэгдлээс 1,191,029.7 мянган төгрөгөөр зэрэг нийт орлого, зарлагыг **4,809,463.3** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 24 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 4,862,844.1 мянган төгрөгөөр, ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 801,073.5 мянган төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 1,560,734.0 мянган төгрөг, ХХС-ийн орлогоос 204,940.0 мянган төгрөг зэрэг нийт **7,429,591.6** мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2024 оны 19 дүгээр тогтоолоор дараах өөрчлөлтийг оруулан төсвийн орлого,

зарлагыг **394,994.9** мянган төгрөгөөр нэмэгдүүлж **7,824,586.5** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

Эх үүсвэрийн өөрчлөлт:

- Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 123,956.6 мянган төгрөгөөр,
- ХХОАТ-ын орлогыг 238,080.3 мянган төгрөгөөр,
- Хөрөнгийн албан татварыг 25,000.0 мянган төгрөгөөр,
- ХХОАТ-ын буцаалтыг 131,035.6 мянган төгрөгөөр,
- Улсын тэмдэгтийн хураамжийг 10,000.0 мянган төгрөгөөр,
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж 10,000.0 мянган төгрөгөөр,
- Хүү торгуулийн орлогыг 113,278.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Ус, рашаан ашигласны төлбөрийг 19,997.0 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Төсвийн зарлагын өөрчлөлт:

- ЗДТГ-ыг 26,197.0 мянган төгрөгөөр,
- Соёлын төвийн тогтмол зардлыг 59,057.9 мянган төгрөгөөр,
- Ерөнхий боловсролын сургуулийн тогтмол зардлыг 296,387.0 мянган төгрөгөөр,
- Сургуулийн өмнөх боловсролын тогтмол зардлыг 98,678.8 мянган төгрөгөөр,
- Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг 83,157.7 мянган төгрөгөөр,
- ОНХС-г 13,703.9 мянган төгрөгөөр,
- ОНХО-ыг 18,000.0 мянган төгрөгөөр,
- ХХС-г 97,448.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Аймагт төвлөрүүлэх орлогыг 468,395.9 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 832,933.0 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 1,553,942.8 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 205,584.3 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөлтөөс, 5,232,126.4 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос зэрэг нийт **7,824,586.5** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 803,780.4 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 5,576,272.2 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 125,631.6 мянган төгрөгийг ХХС-ийн орлогоос зэрэг нийт **6,505,684.2** мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **6,558,201.0** мянган төгрөг буюу **83.5** хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 141,750.8 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 54,303.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 735,698.3 мянган төгрөгөөр, ХХС-аас олгох зээлийг 288,646.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 16 төсөл, арга хэмжээнд 1,294,042.3 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 926,072.8 мянган төгрөгийн санхүүжилт олгон, 278,042.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь тендер зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй, гэрээ байгуулаагүй гэх шалтгаанаар 4 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйгээс голлон шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДНХ-өөс 183,9 мянган төгрөг, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас 10,200.4 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс 1,337.4 мянган төгрөг, БТСГ-аас 800.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 22,353.5 мянган төгрөг зэрэг нийт **34,875.2** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд сумын ОНХО, ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх 10 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 10. Худалдан авах ажиллагаа

/мянган төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Нийт төсөл, арга хэмжээ		Үүнээс					
			Шууд худалдан авалт		Харьцуулалтын арга		Нээлттэй тендер шалгаруулалт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ОНХС	10	953,000.0	1	20,000.0	8	678,000.0	1	255,000.0
Сумын ОНХО	2	118,000.0	1	18,000.0	1	100,000.0	-	-

Эх сурвалж: www.tender.gov.mn

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сайхан сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Байгууллагын үндсэн хөрөнгийн үнэлгээтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын ТТЗ нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/110 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 4,507,575.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **45,075.8** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сайхан сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- 2024 онд нийт 7,852,282.3 мянган төгрөгийн зарлагын төлөвлөгөөтэй бөгөөд 6,558,201.0 мянган төгрөг буюу 83.5 хувийн гүйцэтгэлтэй 1,294,081.3 мянган төгрөгийг хэмнэж ажилласан,
- Төсвийн ил тод байдлыг хангах үүднээс 15 байгууллага бүр шилэн данс хөтөлж хэвшсэн ба сар бүрийн орлого зарлага өглөг, авлага тушаал шийдвэрийг хуулийн хугацаанд шилэн дансанд оруулдаг. Мөн байгууллага бүр ил тод байдлын самбартаа сарын мэдээгээ байршуулж ажилладаг,
- Төсвийн мөнгөөр хандив тусламжийн шинжтэй гүйлгээ гараагүй, Төсвийн тухай хуулийн хөтөлбөр зориулалтын дагуу эдийн засгийн ангиллаар зардал гаргасан,
- Аливаа үйл ажиллагаа зохион байгуулахдаа арга хэмжээг төсөл хөтөлбөртэй нь уялдуулан санхүүжүүлсэн,
- Төсвийн байгууллагын авто машиныг бүрэн цэнхэр дугаартай болгосон,
- Төрийн албан хаагчид олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлаас төрийн албан хаагчдад олгодог 5 жилийн тэтгэмж, ажилчин тэтгэвэрт гарахад олгодог 36 сарын тэтгэмж зэргийг олгосон ба эдгээртэй давхардуулан тэтгэмж олгоогүй
- Шуудан холбооны зардлаас төрийн зарим чиг үүрэгтэй холбоотой төрийн мэдээллээс бусад төрлийн захиалга хийгээгүй,

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 33 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн заалтыг зөрчсөн **31,911.6** мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

ЗДТГ:

- Сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулган хадгалан үлдэх зорилгоор 4,879.6

мянган төгрөгийг “Монголын баялаг өв соёл” ХХК-тай гэрээ байгуулан шилжүүлсэн,

- Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас 20,000.0 мянган төгрөг, ЗДНХ-өөс 5,000.0 мянган төгрөг, зэрэг нийт 25,000.0 мянган төгрөгийг мөрийн хөтөлбөрийн биелэлтийн видео, “Хөтөл хот” дууны клип, сумын ЗДТГ-ын 40 жилийн ойн баримтат нэвтрүүлэг зэргийг хийлгэх зорилгоор “МЭ маркетинг энтертайнмент” ХХК-тай шууд гэрээ байгуулан шилжүүлсэн,
- “Хөтлийг бүтээсэн эрхмүүд” ном худалдан авахад 1,500.0 мянган төгрөг шилжүүлсэн,

Номгон тосгоны Захирагчийн алба:

- Бэлэг дурсгалын зүйл бэлтгэх зардалд 532.0 мянган төгрөг шилжүүлсэн.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4: “...аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, 15.1.5: “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 11. Шилэн данс

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	181	176	5	-
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	183	181	2	-
3	Засаг даргын Тамгын газар	183	172	11	-
4	Номгон тосгоны Захирагчийн алба	183	181	2	-
	Нийт дүн	730	710	20	-

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

ТТЗ-ийн түвшинд нийт мэдээлбэл зохих 730 мэдээллээс 710 мэдээллийг хугацаанд нь, **20** мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж үзлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулахаас зайлсхийж, харьцуулалтын аргын босго үнэд багтаах зорилгоор ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжихээр төлөвлөсөн **185,000.0** мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий “*малын усалгааны систем шинээр суурилуулах*” төсөл, арга хэмжээг **2** төсөл, арга хэмжээ болгон төлөвлөж, хэрэгжүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь “*Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно*”, Засгийн газрын 2024 онд батлагдсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 2 дахь: “*Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар - Бараа 150.0 сая төгрөг*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилган давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 172 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад **83.3** хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	96,636.5	4	96,636.5	100.0
Зөвлөмж	2	15,290.0	1	1,075.0	50.0
Нийт дүн	6	111,926.5	5	111,926.5	83.3

Өмнөх оны аудитаар өгсөн нэмэлт санхүүжилтээр авсан бараа материалыг орлого авч, бүртгэл тайлант тусгах зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа.

Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”, “ОНХС-ийн 2024 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

2. Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны улсын ахлах байцаагчийн 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 04/32-01 дүгээр төлбөрийн актаар тогтоосон 8,157.8 мянган төгрөгийн зээлийн алдангийг эзэн холбогдогчоос бус ХХС-ийн төсвөөс төлж барагдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 1.5 дахь “*Сангийн хөрөнгө нь суманд хоршоо санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, сургалт зохион байгуулах, хяналт тавих, авлага барагдуулах, урамшуулал олгоход зориулагдана.*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой нийт **459,019.4** мянган төгрөгийн алдаа илэрч аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагад төлөх өглөгийг 459,019.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,

Аудитаар нийт **42,795.1** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 4,454.2 мянган төгрөгийн төлбөрийн акт, 38,340.9 мянган төгрөгийн албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

1. Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “*Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам*”-ын дагуу орон нутагт тогтвор

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас нийт **4,454.2** мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ИТХ нь 1 албан хаагчийн 8,755.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас 875.5 мянган төгрөгийг,
- ЗДТГ нь 4 албан хаагчийн 29,107.1 мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас 2,910.7 мянган төгрөгийг,
- Номгон тосгоны Захирагчийн алба нь 1 албан хаагчийн 6,680.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас 668.0 мянган төгрөгийг тус тус суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 6.3.1: “... урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 22 дугаар зүйлийн 22.1 дэх “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө” 22.1.1: “хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ-ыг нөхөн суутгаж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.1 Албан шаардлага

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар, хөтөлбөр, зориулалт, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй **11,853.5** мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

ИТХ:

- Бараа үйлчилгээний бусад зардлаас бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,135.5 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 300.0 мянган төгрөг,

ЗДТГ:

- Ном хэвлэлийн зардлаас бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 10,000.0 мянган төгрөг,
- Урсгал засварын төсвөөс бичиг хэргийн зардалд 115.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 303.0 мянган төгрөг,

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

2. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс Хот тохижилтын газар нь **6,487.4** мянган төгрөгийн НДШ-ийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3. ЗДТГ нь өмнөх оны аудитаар өгсөн нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээр худалдан авсан бараа материалыг бүртгэл тайланд тусгах зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд **20,000.0** мянган төгрөгийн нөөцийн өвс, тэжээл /10,000.0 мянган төгрөгийн 1,250 ширхэг өвс, 10,000.0 мянган төгрөгийн 400 шуудай хивэг/-ийг бараа материалын дансанд орлого авалгүйгээр шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:” 14.4.5 дахь “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын хөдлөл өөрчлөлтийг тухай бүр бүртгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа **63** нэр төрлийн ИТХ-7, ЗДТГ-40, Захирагчийн алба-14/ хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн шийдвэрлүүлэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	1	459,019.4			1	459,019.4	1	459,019.4				
Дүн	1	459,019.4			1	459,019.4	1	459,019.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ИТХ	2	2,311.0	1	875.5	1	1,435.5						
ЗДТГ	4	33,328.7	1	2,910.7	2	30,418.0	1					
Захирагчийн алба	1	668.0	1	668.0								
Хот тохижилт	1	6,487.4			1	6,487.4						
ТТЗ-ийн Дүн	8	42,795.1	3	4,454.2	4	38,340.9	1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1							1
Дүн	1							1
ТБОНӨХБАҮХАТ хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу төлөвлөж, зохион байгуулаагүй	1	185,000.0			1	185,000.0		
Дүн	1	185,000.0			1	185,000.0		
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтыг зөрчсөн	1	31,911.6			1	31,911.6		
Дүн	1	31,911.6			1	31,911.6		
Нийт дүн	3	216,911.6			2	216,911.6	1	